



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 02 сарын 02 өдөр

Дугаар 17/16

Бат-Өлзий сум

Төсөл хэрэгжүүлэх ажлын
хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.13, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.5 дахь заалт, аймгийн Засаг даргын "Төсөл хэрэгжүүлэх тухай" 2023 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн А/47 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. СТАРТ сангийн санхүүжилтээр "Дэлхийн зөн" олон улсын байгууллагатай хамтран суманд зудын хохирлыг бууруулах хүрээнд цөөн малтай малчин өрхийг хамруулах буцалтгүй тусламж, өвс тэжээлийн дэмжлэг үзүүлэх "Цагийн хүндийг хамтдаа" төслийн ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга: Н.Бат-Эрдэнэ (Засаг даргын Тамгын газрын дарга)
Гишүүд: Э.Буянтогтох (Малын үржил, бүртгэлийн асуудал хариуцсан мэргэжилтэн)

Багийн Засаг дарга нар

Т.Эрдэнэбаяр (Хүнс, хөдөө аж ахуйн газрын мал үржлийн албаны бэлчээр газар тариалан, усан хангамж хариуцсан мэргэжилтэн)

Т.Мягмарсүрэн (Дэлхийн зөн олон улсын байгууллагын Өвөрхангай аймаг дахь дотоод хүүхэд ивээн тэтгэх хөтөлбөрийн зохицуулагч)

Г.Дондогсэрчин (иргэний төлөөлөл)

Г.Сугар (иргэний төлөөлөл)

Нарийн бичгийн дарга: Н.Түвшин (Бэлчээр, газар тариалангийн асуудал хариуцсан мэргэжилтэн)

2. Төслийн шаардлагад нийцсэн малчин өрхүүдийг сонгож, төслийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж ажиллахыг ажлын хэсгийн дарга (Н.Бат-Эрдэнэ)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

С.АМГАЛАН

